

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар А-276

Улаанбаатар хот

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ ГАРГАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1."Гадаад валютын арилжааны мэдээ гаргах журам"-ыг хавсралтаар баталсугай. 2.Гадаад валютын арилжааны мэдээг энэ журмын дагуу хүлээн авч байхыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин)-т үүрэг болгосугай.
- 3.Гадаад валютын арилжааны мэдээг Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт энэ журмын дагуу ирүүлж байхыг бүх банкны гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
- 4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай), Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин)-т тус тус даалгасугай.
- 5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн А-26 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН